

КОВИД-19 ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫН НӨХЦӨЛД СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГААС СУРАЛЦАХ НЬ

Шинэ төрлийн коронавирусын халдварын тархалт дэлхий нийтийг түгшээж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрөөд байна. БНХАУ-тай газар зүйн хувьд ойр байрлаж, 4709 км газраар хил залгадаг Монгол Улсын хувьд цар тахлын голомтын эрсдэл өндөр байсан ч халдвар тархахаас урьдчилан сэргийлэх шийдмэг арга хэмжээг 2020 оны 2-р сараас эхлэн цаг алдалгүй авч хэрэгжүүлсний үр дүнд өнөөг хүртэл КОВИД-19-ийн халдварын тохиолдол хамгийн цөөн тоологдсон бөгөөд дотооддоо халдварласан тохиолдол болоод нас баралт хараахан бүртгэгдээгүй байгаа хэдхэн улсын нэг болж байна. Харин ойрын үед хамгийн их

анхаарал татаж буй нэг зүйл бол КОВИД-19-ийн тархалтаас сэргийлэх зорилгоор улс даяараа өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж хараахан дуусгавар болоогүй байгаа нөхцөлд 6-р сарын 24-нд явуулахаар товлосон Улсын Их Хурал (УИХ)-ын ээлжит сонгуулийг хэрхэн эрсдэлгүй зохион байгуулах тухай асуудал юм.

Энэ амаргүй цаг үед манайхтай ижил ээлжит сонгууль товлосон ардчилсан улс цөөнгүй байгаа бөгөөд тэдгээр улс сонгуулиа хойшлуулах эсэх, хэрэв хугацаанд нь зохион байгуулах бол ямар арга хэмжээ авах талаар адармаатай сорилттой тулгарч байна.



АНТониО СПИНЕЛЛИ

АСДҮОУХ-гийн Ази, Номхон далайн бүс нутгийн хөтөлбөрт Сонгуулийн үйл явц, улс төрийн оролцооны асуудлаар ахлах зөвлөхөөр ажилладаг. 2017-2019 онд Канберра дахь Ази, Номхон далайн бүсийн хөтөлбөрт ажиллаж байгаад эдүгээ Балба Улс, Өмнөд Азид хэрэгжүүлж буй сонгуулийн үйл явц, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоо, улс төрийн төлөөлөл, оролцооны асуудлаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийг удирдах болсон.

Тэрбээр 1992 оноос эхлэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Сонгуулийн системүүдийн олон улсын хүрээлэн (IFES), Европын комисс зэрэг олон улсын байгууллагуудад ажиллаж сонгуультай холбоотой бодлого боловсруулах, улс төрийн шилжилт хийсэн ардчилсан улсууд, зөрчилтэй болон зөрчлөөс ангижирсан улсуудад хэрэгжсэн томоохон хэмжээний техникийн туслалцаа үзүүлэх төслүүдийг удирдах ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай.



Д.ЭНХЦЭЦЭГ

ННФ-ын Засаглалын асуудлаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хариуцан ажилладаг. 2008 оноос хойших УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудад иргэний нийгмийн зүгээс хийсэн хяналт, мониторингийн ажилд арга зүйн туслалцаа үзүүлэн, удирдан ажилласан бөгөөд энэхүү ажиглалтууддаа тулгуурлан сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох чиглэлээр харьцуулсан судалгаа, шинжилгээ хийхэд түлхүү анхааран ажиллаж байна.

Тэрбээр Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Дээд Сургууль, Унгар дахь Төв Европын Их Сургууль, АНУ-ын Хавайн Их Сургуульд үндэстэн, соёл судлал, нийтийн удирдлагын чиглэлээр суралцаж төгссөн ба 2011-2012 онд Австралийн Сидней Их Сургуулийн Хуулийн сургуульд суралцан мэргэжил дээшлүүлж Захиргааны эрх зүй, нийтийн бодлогын чиглэлээр дахин Магистрын зэрэг хамгаалжээ.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ)-гээс эрхлэн Дэлхий даяарх КОВИД-19-ийн тархалт ба сонгуульд үзүүлэх нөлөө (Global Overview of COVID-19: Impact on Elections)-г судлан байнга шинэчилж буй тоо, мэдээллээс үзэхэд 2020 оны 4-р сарын байдлаар 50 шахам орон, муж, нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварын тархалт хүндрэхээс сэргийлэн сонгуулиа хойшлуулах шийдвэр гаргаад байв. Түүнчлэн хэд хэдэн улс эрсдэлийг үл хайхран ээлжит сонгуулиа цаг хугацаанд нь зохион байгуулаад байна. Үүнд Австрали (Кюинсланд мужийн орон нутгийн сонгууль), Бүгд Найрамдах Доминикан Улс (хотын сонгууль), Франц (орон нутгийн сонгууль), Герман (Бавари мужийн орон нутгийн сонгууль), Гуяна Улс (үндэсний хэмжээний ээлжит сонгууль), Израил Улс (үндэсний хэмжээний ээлжит сонгууль), Мали Улс (үндэсний хэмжээний ээлжит сонгууль), Швейцар Улс (орон нутгийн сонгууль), Вануату Улс (үндэсний хэмжээний ээлжит сонгууль) зэрэг жишээг дурдаж болно.

Монгол Улсын хувьд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол Улсын Их Хурал ээлжит сонгуулийг хойшлуулж болно”, “Сонгууль товлон зарласны дараа энэ хуулийн 9.4-т заасан онцгой нөхцөл бий болсон тохиолдолд Улсын Их Хурал ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсоож болно” гэж заасан. Тодруулбал, Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт

заасны дагуу “улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон нөхцөлд” УИХ онц байдал тогтоож, улмаар ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсоон, хойшлуулах шийдвэр гаргах эрхтэй. Одоогийн байдлаар Улсын онцгой комиссоос улс даяар шилжсэн хагас өндөржүүлсэн бэлэн байдлыг 2020 оны 5-р сарыг дуустал сунгахаар шийдвэрлээд байгаа боловч УИХ-ын зүгээс онц байдал зарлах нөхцөл үүсээгүй гэж үзэж буй нь тодорхой байгаа бөгөөд ээлжит сонгуулийн үйл ажиллагаа СЕХ-ны 2020 оны 2-р сарын 7-ны 03 тоот тогтоолоор баталсан сонгуулийн ажлын цаг хугацааны хуваарийн дагуу хэвийн явагдаж байна.

Ийм онцгой нөхцөлд сонгуулийн санал хураах болон бусад үйл явцыг хэрхэн эрүүл аюулгүй орчинд, маргаан зөрчлөөс ангид зохион байгуулах нь нэн тэргүүнд анхаарах асуудал болоод байна. Үүнд чиглэсэн тодорхой шийдэл, арга хэмжээ төлөвлөхөд КОВИД-19-ийн тархалтын үед сонгууль зохион байгуулсан бусад улсуудын сайн туршлагыг судлах нь чухал гэж үзэн улсын хэмжээний томоохон сонгуулийг халдварын тархалтыг хүндрүүлэлгүй амжилттай явуулсан орнуудын нэг болох Бүгд Найрамдах Солонгос Улсын туршлагыг онцлон авч үзлээ. Өмнөд Солонгосын Үндэсний Ассамблейн 300 гишүүнийг сонгох 21 дэх удаагийн сонгууль нь 2020 оны 4-р сарын 15-ны өдөр болж өнгөрсөн билээ.

ЦАР ТАХАЛ НҮҮРЛЭСЭН НӨХЦӨЛД СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ӨМНӨД СОЛОНГОСЫН ТУРШЛАГА

БНХАУ-аас гадна энэ оны 2-р сарын байдлаар КОВИД-19 хурдтай тархсан орны нэг нь Өмнөд Солонгос улс байв. Тус улсын засгийн газар нь халдварын тархалтын эсрэг оношилгоо шинжилгээ, хяналт, хавьтлын илрүүлэлт, өөрийгөө тусгаарлах болон олон нийтийн газар бусдаас зай барих шаардлага, гадаадаас ирсэн зорчигчдыг хатуу хөл хорионд байлгах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Үүнтэй зэрэгцэн 2020 оны Үндэсний Ассамблейн сонгуулийг 4-р¹ сард товлосон хугацаанд нь зохион байгуулах боломжтой эсэх талаар улс төрийн хүрээнд болон нийгэмд маргаан өрнөж тодорхойгүй нөхцөл байдал үүсээд байсан нь ч вирусийн халдварын тархалтыг амжилттай намжааж чадсанаар сонгуулиа цаг хугацаанд нь зохион байгуулах нь зүйтэй гэсэн шийдэлд хүрчээ.

КОВИД-19-ийн тархалтын үед үндэсний хэмжээнд томоохон сонгууль зохион байгуулж түүчээлсэн анхны орнуудын нэг болох тул Өмнөд Солонгосын 21 дэх удаагийн Үндэсний Ассамблейн сонгууль нь бэлтгэл хангах үе шатнаас эхлээд дэлхий нийтийн сонирхлыг татаж эхэлсэн билээ. Дэлхийн бүх тивийн улсуудын сонгуулийн төв байгууллага, сонгуулийн мэргэжилтнүүд, судлаач эрдэмтэд, иргэний нийгмийн төлөөлөл, улс төрчид Өмнөд Солонгосын туршлагыг эхнээс нь дуустал нүд салгалгүй ажигласан гэхэд болно. Халдварт өвчний тархалт газар авсан онцлог бөгөөд бэрхшээлтэй нөхцөл байдалд сонгууль зохион байгуулсан Солонгосын Үндэсний Сонгуулийн Хороо (ҮСХ) -ны туршлагаас дараах хэд хэдэн асуудал гол анхаарал татаж байв:

- Санал хураах байрны эрүүл аюулгүй орчныг хангахын тулд ямар ямар арга хэмжээ авсан бэ? Эдгээр нь сонгогчдод итгэл үнэмшил төрүүлж сонгуульдаа идэвхтэй оролцох баталгаа болж чадсан уу?

- Цар тахал нь улс төрийн намуудын сонгуулийн кампанит ажил, сонгогчидтой ажиллах боломжид хэрхэн нөлөөлсөн бэ?
- КОВИД-19-тэй холбоотой эрсдэлээс болгоомжилсон сонгогчид саналаа өгөхгүй байх нөхцөл үүсэх үү, энэ нь сонгуулийн ирцэд хэрхэн нөлөөлөх вэ? Цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдал нь сонгуулийн хууль ёсны байх буюу легитим чанарт нөлөөлөх үү?
- Эцэст нь сонгуулийг товлосон цаг хугацаанд нь зохион байгуулах шийдвэр сонгогчдын болоод сонгуулийн ажилтнуудын эрүүл мэндэд эрсдэл учруулах уу?

Онцгой нөхцөл байдалд тохируулан онцгой арга хэмжээ авсан нь

КОВИД-19-тэй холбоотой хямрал эхэлсэн цагаас ээлжит сонгуулийг товлосон цаг хугацаанд нь зохион байгуулах албан ёсны шийдвэр гарах хүртэл ҮСХ-ны зүгээс сонгогчдод саналаа өгөхөд аливаа эрсдэл үүсэхгүй эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд анхаарал хандуулж, улмаар албан ёсны шийдвэр гарсан даруй яаралтай арга хэмжээ авч эхэлсэн аж. ҮСХ-ны дарга сонгогчдод хандан гаргасан мэдэгдэлдээ “Сонгуулийн зохион байгуулалтын гол ажил нь ариутгал халдваргүйжүүлэлтийг дээд зэргээр хийхэд чиглэх ба энэ хүрээнд ҮСХ сонгогч эрүүл мэнддээ санаа зовох зүйлгүй саналаа өгөх орчныг бүрдүүлэхийн төлөө зохих арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх болно” гэж дурджээ. Ийнхүү амласнаа нэн даруй ажил хэрэг болгож сонгогч санал өгөх явцдаа вирусийн халдвар авч, бусдад түгээхээс сэргийлэх зорилготой хэд хэдэн онцгой арга хэмжээ авахаа зарласан. Үүнд:

Урьдчилж болон гэрээсээ санал өгөх

Урьдчилж санал өгөхийг хөхиүлэн дэмжих. Эдгээр арга хэмжээний эхнийх нь сонгогчдод урьдчилж санал өгөх боломж олгосон хуулийн зохицуулалтыг аль болох түлхүү ашиглахыг хөхиүлэн дэмжих явдал байв. Энэ зохицуулалтыг

¹ Бүх нийтийн албан ёсны сонгуулийн тухай хуулийн (Public Official Election Act) 196-р зүйлд зааснаар Ерөнхийлөгч “байгалийн гамшиг, газар нутгийг хамарсан бусад аюул тохиолдсон, эсхүл бусад зайлшгүй нөхцөл” үүссэн бол сонгуулийг хойшлуулах эрхтэй.

Солонгос Улс 2013 онд болсон нөхөн сонгуулиар анх хэрэгжүүлсэн ба дараа жил нь орон даяар зохион байгуулсан орон нутгийн сонгуульд бүрэн нэвтрүүлж сонгогчид сонгуулийн өдрөөс өмнө оршин суугаа хаяг хамаарахгүй, байгаа газраа санал өгөх боломж олгосон. 2020 оны сонгуулийн хувьд урьдчилж санал хураах үйл ажиллагаа 4-р сарын 10-11-ний өдрүүдэд явагдсан бөгөөд сонгогчид улс даяар үйл ажиллагаа явуулж эхэлсэн 3500 санал хураах байрны алинд ч очиж саналаа өгөх боломжтой байв. Ийнхүү аль болох олон сонгогчийн саналыг урьдчилж өгүүлэхээр хичээсэн нь сонгуулийн өдрийн ачааллыг бууруулж сонгогчид олноор бөөгнөрөхөөс сэргийлэх зорилго агуулж байлаа.

Гэрээс санал өгөх (шуудангаар урьдчилж санал өгөх) боломжийг ашиглах. Бас нэг чухал арга хэмжээ нь КОВИД-19-өөр өвчлөн эмчлүүлж байгаа хүмүүс, хөл хорионд тусгаарлагдсан болон халдвар авсан хүмүүстэй хавьталд орсны улмаас

өөрийгөө тусгаарлаад буй хүмүүст “гэрээс санал өгөх (шуудангаар урьдчилж санал өгөх) боломж” олгосон. Хэвийн нөхцөлд болж өнгөрсөн өмнөх сонгуулиудад зөвхөн тусгайлан заасан тодорхой нөхцөлд сонгогч² гэрээсээ санал өгөх боломжтой байж ирсэн. Энэ удаад шуудангаар санал өгөхийн тулд сонгогч 3-р сарын 24-28-ны хооронд “гэрээс санал өгөх” өргөдлийн маягт бөглөн орон нутгийн засаг захиргааны байгууллагадаа хүргүүлэх журамтай байлаа.

“Гэрээс санал өгөх” хүсэлт хүлээж авах хугацаа албан ёсоор дуусгавар болсны дараа ҮСХ-ноос КОВИД-19-ийн халдвар авсан хүмүүсийн сонгох эрхийг хангах нэмэлт арга хэмжээ авсан нь эмнэлэг болон эрүүл мэндийн байгууллага дээр тусгай санал хураах байрууд байгуулж халдвар аван эмчлүүлж буй сонгогчид болон эмнэлгийн ажилтнуудад урьдчилж санал өгөх боломж олгосон явдал байв.

Манай нөхцөлд хэрэгжүүлэх боломж

Солонгост авч хэрэгжүүлсэн сонгогчдын саналыг урьдчилж авах арга хэмжээг Монгол Улсад авч хэрэгжүүлэх боломж хуулийн хүрээнд хязгаарлагдмал юм. УИХ-ын сонгуулийн 63-р зүйлийн 63.1 дэх хэсэгт зааснаар эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй, дайчилгааны тухай хуульд заасны дагуу нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа болон зөрчлийн улмаас баривчлагдсан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцагар авах боломжтой. Зөөврийн битүүмжилсэн хайрцагар санал авах ажиллагааг сонгогчийн гаргасан хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд явуулахаар хуульчилсан байна. Харин хуульд заасан хүндэтгэх шалтгаангүй сонгогчдын хувьд санал авах өдөр өөрийн биеэр санал хураах байранд ирж саналаа өгөхөөс өөр аргагүй. Ийм нөхцөлд санал хураах байранд олон хүн бөөгнөрөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж нэг санал хураах байранд ногдох сонгогчдын тоог аль болох цөөн байхаар тооцон, ариутгал халдваргүйжүүлэлтийн бусад арга хэмжээг судалж нэвтрүүлэх нь зүйтэй.

² Үүнд тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөлгөөний бэрхшээлтэй ахмадууд, эмнэлэг, асрамжийн газар болон саатуулагдан хоригдсон хүмүүс багтана.

Санал авах байрны эрүүл, аюулгүй орчин

Солонгосын ҮСХ-ны зүгээс 4-р сарын 15 буюу сонгуулийн өдөр нийт 14,330 санал хураах байранд биеэр ирж санал өгөх сонгогчдод эрүүл аюулгүй нөхцөлд санал өгөх боломжийг бүх талаар хангах шийдмэг арга хэмжээнүүд авсан. Энэ хүрээнд санал хураах үйл явцын бүхий л үе шатанд халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлж санал хураах байрны гадна дугаарлахад зай барихаас эхлээд санал хураах байрны дотор байж болох сонгогчдын тоог зохицуулж хязгаарлах, сонгуулийн төхөөрөмж, материалтай харьцахад аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнтэй холбоотой авсан нэг чухал арга хэмжээ нь Сонгогчдод зориулсан санал өгөхөд баримтлах журам байв. Энэхүү журамд санал өгөх алхмуудыг нарийвчлан зааварлаж, эдгээр алхам бүрт сонгогчдын дагах ёстой урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой зааж өгсөн байлаа. Улмаар уг журмыг сонгогчдод аль болох өргөнөөр хүргэж сонгуулийн өдөр саналаа өгөх бэлтгэл хангахад нь ҮСХ-ны зүгээс ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилласан байна.

Санал өгөхөд сонгогчдын баримтлах журамд дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгажээ:

- Санал өгөхөөр дугаарлахдаа амны хаалт заавал зүүх.
- Санал хураах байранд нэвтрэхийн өмнө биеийн температурыг зайнаас халуун хэмжин термометрээр шалгах ба халуун нь 37.5 хэмээс дээш байгаа болон амьсгалын замын өвчний шинж тэмдэг, зовуур илэрсэн тохиолдолд өндөр зэрэглэлийн урьдчилан сэргийлэх хамгаалалт бүхий тусгай өрөөнд санал өгөх.
- Сонгогчид хоорондоо наад зах нь 1 метрийн зай барьж аюулгүй байдлаа хангах, ийнхүү зай барихад зориулж санал авах байруудад зохих тэмдэглэгээг хийх.
- Биеийн байцаалт/Иргэний үнэмлэхээ шалгуулахад бэлэн байх, гараа ариутгагчаар цэвэрлэн, тавьж өгсөн нэг удаагийн бээлий өмсөх.
- Санал хураах байранд нэвтэрсэн сонгогч тухайн хэсэгт санал өгөх сонгогч мөн эсэхээ шалгуулах үед амны хаалтаа доошлуулах буюу түр авах.
- Үүний дараа амны хаалтаа дээшлүүлэх буюу буцаан зүүж, бээлийтэй гараар саналын хуудсаа авч бөглөн саналаа өгөх.
- Эцэст нь санал хураах байрнаас гарахдаа бээлийгээ тайлж гарах хаалганы хажууд байрлах саванд хаях.

Санал хураах байранд ажиллах сонгуулийн ажилтнуудад мөн заавал дагаж биелүүлэх тусгай журам, тодорхой заавар гарган мөрдүүлжээ. Үүнд, эрүүл ахуйн хатуу журам баримталж амны хаалт зүүх, бээлий өмсөх, сонгуулийн урд өдөр нь санал хураах байруудыг ариутган халдваргүйжүүлэх, улмаар санал хураалт эхлэхээс өмнө нэвтрэхийг хориглох, санал өгөх бүхээг, тамга болон бусад сонгуулийн материалыг тогтмол ариутгаж, санал хураах байруудыг сайтар агааржуулахад анхаарах зэрэг арга хэмжээг заасан байв.

Дээрх аюулгүй байдлын арга хэмжээтэй төстэй заалтууд тусгасан журмыг мөн цагдаагийн болон хэвлэл мэдээллийн ажилтнууд, сонгуулийн ажиглагчдад зориулан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллажээ. КОВИД-19-өөр өвчилсөн 3000 өвчтөн, тэдэнд эмнэлгийн туслалцаа үзүүлж байсан 1000 эмч, эмнэлгийн ажилтанд зориулан Сөүл, Дэгү хотуудад байгуулсан тусгай санал хураах байранд томилогдсон сонгуулийн ажилтнуудын хувьд бүх биеийг халхалсан хамгаалалтын хувцас, нүүрний халхавч, амны хаалт, нэг удаагийн бээлий зэргийг өмсөн халдвараас хамгаалж, урьдчилан сэргийлсэн байна. ҮСХ-ны мэдээлснээр ийнхүү тусгай арга хэмжээнүүдийг шат дараатай авахад 20,000 сонгуулийн ажилтан нэмж ажиллуулах шаардлагатай болжээ.

Гэртээ хөл хорионд байсан сонгогчдод зориулан мөн тусгай журам гаргасан ба тэд санал хураалт албан ёсоор хаагдсаны дараа хөл хоригдож байсан газраасаа гарч санал хураах байранд биеэр санал өгөх боломжтой байсан байна.

Ийнхүү сонгогчдод чиглэсэн дотооддоо авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс гадна гадаадад оршин сууж буй сонгогчид саналаа өгөхтэй холбоотой зарим шийдвэр, арга хэмжээ мөн авчээ. Тухайлбал, КОВИД-19-ийн тархалт хүндэрсэн улсуудад оршин сууж буй иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, хөл хорио тогтоосон зарим оронд гарч явж санал өгөх боломжгүйг харгалзан, 55 оронд санал хураах үйл ажиллагааг цуцалсан ба зарим элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар санал хураах цагаа богиносгосон байна.

Манай нөхцөлд хэрэгжүүлэх боломж

Монгол Улсын хувьд дээр дурдсанчлан сонгогч саналаа урьдчилж өгөх эрх зүйн орчин хязгаарлагдмал ба санал авах өдөр гадаадад байж таарах сонгогчдын хувьд санал өгөх боломжгүй.

Ийм нөхцөлд сонгогчдын дийлэнх нь санал хураах байранд биеэр ирж саналаа өгөх тул санал хураалтын үйл ажиллагааг сонгогчдын эрүүл мэндэд эрсдэлгүй байдлаар зохион байгуулахад гол анхаарлаа хандуулах шаардлагатай болж байна. СЕХ-ны зүгээс санал хураах байруудыг ариутган халдваргүйжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлыг цогц байдлаар яаралтай төлөвлөн олон нийтэд мэдээлж, шат дараатай авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

КОВИД-19-ийн цар тахлын эрсдэл нүүрлэсэн өндөржүүлсэн бэлэн байдалд сонгууль явуулахад ямар журам баримтлах талаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй УИХ-ын сонгуулийн тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй. Гэвч хуулийн 62.9-д “Санал авах ажиллагааг зохион байгуулах, санал авах байр бэлтгэх заавар, түүнчлэн саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээгийн хэмжээ, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална” гэж заасан байх ба Сонгуулийн Төв байгууллагын тухай хуулиар СЕХ-нд олгогдсон бүрэн эрх, Гамигаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудын хүрээнд Өмнөд Солонгосын туршлагад үндэслэн шаардлагатай арга хэмжээ авах боломжтой байна. Ялангуяа, сонгогчдод хамаатай журам заавар гаргах нөхцөлд аль болох яаравчлан баталж, олон нийтэд сурталчилж, мэдээллээр хангахад анхаарах нь зүйтэй.

Иргэдийг мэдээллээр хангах

Солонгосын ҮСХ сонгогчдод мэдээлэл өгөхийн тулд харилцаа холбооны янз бүрийн арга хэрэгсэл ашигласны дотор өөрийн NEC eTV болон үндэсний телевизийн сувгуудаар санал өгөхтэй холбоотой мэдээлэл сурталчилгаа тогтмол явуулах, орон даяар зурагт хуудас, мэдээллийн самбар байрлуулах, Сонгогчдын санал өгөх журмыг санал хураах байруудад урьдчилан санал хураахаас эхлээд сонгуулийн өдрийг хүртэл тавьж танилцуулсан байна.

Санал хураах, тоолох үйл явцын ил тод байдлыг хангах

Ардчилсан шударга сонгуулийн нэг гол зарчим нь ил тод байдал байдаг. Сонгуулийн бүхий л үйл явцад оролцогч талууд хяналт тавих боломжтой нээлттэй байх нь сонгуулийн үйл явц, үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болно. КОВИД-19-ийн тархалттай холбоотой нэлээд улс орнууд олон улсын хуваарьт нислэгүүдээ хязгаарлаад байгаагаас үүдэн олон улсын ажиглагчид УИХ-ын ээлжит сонгуулийг

ажиглах боломжгүй нөхцөл үүсэх магадлалтай байгаад зарим оролцогч талууд санаа зовниж буйгаа илэрхийлж эхлээд байна. Өмнөх УИХ-ын сонгууль буюу 2016 оны сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдийн ажиглагчдаас гадна гадаадын 200 орчим ажиглагч, дотоодын иргэний нийгмийн байгууллагуудын 300 гаруй ажиглагч хяналт тавьж ажилласан. Энэ удаагийн сонгуульд ч дотоодын нам бус ажиглагчид хяналт тавихаар бэлтгэлээ базааж эхлээд байгаа билээ.

Өмнөд Солонгосын туршлагаас харахад нийтийн эрүүл мэндийг хамгаалах ҮСХ-ноос онцгой нөхцөл байдалд тохируулан авсан хатуу арга хэмжээ нь сонгуулийн санал хураах, тоолох үйл явцын ил тод, хүртээмжтэй байдалд зарим талаар сөрөг нөлөө үзүүлэх нь зайлшгүй болж ирсэн. Энэ асуудлыг халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг сааруулахгүйгээр шийдэх үүднээс ҮСХ eTV суваг болон үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг сувгуудаар тогтмол давтамжтайгаар хоёр өдөр үргэлжилсэн урьдчилан санал хураалт, мөн сонгуулийн өдрийн санал хураалтын ажиллагааг

шууд нэвтрүүлжээ. Шууд дамжуулалт нь дотоодод болоод гадаадад оршин сууж буй сонгогчдод санал хураалтын бүхий л үйл явц, үүний дотор санал хураах бэлтгэл ажил, санал хураалтыг эхлүүлэх процесс, сонгогчид саналаа өгөх үйл явц, санал хураалтыг хаах, саналын хуудсыг битүүмжлэн хүргүүлэх, тооллогод бэлтгэн, эхлүүлэх ажиллагаа, санал тооллогын явц болон

санал тооллогыг хаах үйл явцыг алсаас ажиглах боломж олгосон байна.

Дээрхээс гадна хүн хоорондын хавьтлаас сэргийлж сонгогчид машинтайгаа дугаарлах боломжтой тусгай санал хураах байр байгуулахаар төлөвлөгөө боловсруулаад байсан ч сонгуулийн өдөр хэт дөхсөн учир хэрэгжүүлэх боломжгүй болжээ.

Манай нөхцөлд хэрэгжүүлэх боломж

Манай нөхцөлд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн хүрээнд сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байна. Сонгуулийн өдрийн үйл явцыг ажиглагчид хянах боломжтой байхаас гадна УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 62.11 дэх хэсэгт “Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна” гэж заасан байна. Эдгээр камерыг ашиглан санал авах байранд өрнөж буй үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжийг иргэдэд олгох нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Сонгуулийн кампанит ажил явуулах арга хэлбэрийг үүсээд буй нөхцөл байдалд тохируулан өөрчлөх

Өмнөд Солонгосын хувьд КОВИД-19-ийн тархалт нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлаа зохион байгуулж ирсэн уламжлалт хэв загварыг эвдсэн гэж дүгнэж болно. Цуглаан, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, мэтгэлцээн хийх, сонгогчдыг олноор нь цуглуулан хандив цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулах, айлуудаар явж ухуулга хийх зэрэг хүмүүстэй биечлэн уулзах, харилцах шаардлагатай арга хэмжээнүүд явуулах боломжгүй байв. Хэдийгээр улс даяар хатуу хөл хорио тогтоогоогүй боловч сонгуулийн өдрийг хүртэл олон хүн оролцуулсан үйл ажиллагаа зохион байгуулах, оролцохыг хориглосноос гадна зай барих, өөр хоорондоо уулзаж харилцахаа аль болох хязгаарлах заавар үйлчилсэн хэвээр байв. Үүнтэй холбоотой улс төрийн нам, нэр дэвшигчид сонгогчдод хүрч ажиллах шинэлэг арга барил нэвтрүүлэхээс өөр аргагүй байдалд хүрсэн аж.

2020 оны сонгуулийн хувьд сонгуулийн сурталчилгаа өмнөх сонгуулиудтай харьцуулахад яах аргагүй “даруухан” болж өнгөрсөн гэж хэлж болно. Сонгогчдод хүрч ажиллахын тулд сурталчилгааны уламжлалт аргаа өөрчлөн Интернэт орчин, цахим технологи ашиглах, үүнд тухайлбал, нийгмийн сүлжээгээр видео сурталчилгаа явуулах, гар утсаар мессеж илгээх, аппликэйшн (app) гаргах гэх мэт арга түлхүү хэрэглэж байв. Түүнчлэн зарим нэр дэвшигч 3D технологид суурилсан хийсвэрээр өргөтгөсөн бодит байдал (augmented reality (AR) technology)³ ашиглан дэмжигчидтэйгээ цахимаар харилцах шинэлэг арга ашиглах ч тохиолдол байлаа. Түүнчлэн КОВИД-19-тэй холбоотой сайн дурын ажил хийх, тойргийнхоо гудамж талбайг ариутган халдваргүйжүүлэх гэх мэт арга хэмжээнд оролцох

³ AR технологи ашигласан нэгэн нэр дэвшигчийн хувьд дэмжигчид нь цахим аппликэйшн, утасны камер ашиглан мөрийн хөтөлбөрийн амлалтыг дэмжиж буйгаа илэрхийлэх боломжтой байсан аж. Зарим нэр дэвшигчид гар утсанд суурилсан AR программаар дамжуулан сонгогчид 3D дүрс бүхий намын төлөөлөгчтэй цахимаар уулзаж харилцах боломжтой байв. AR технологиор дамжуулан энэхүү дүрсжүүлсэн төлөөлөгч нь хэрэглэгчийн авсан зураг, видеонд дүрс нь гарч хэрэглэгч цааш нь шэйрлэх боломжтой.

нэр дэвшигчид ч байв. Бусад нэр дэвшигчийн хувьд уламжлалаас хазайлгүй орон даяар өрх бүрд тараагддаг сонгуулийн мэдээллийн товхимолд сурталчилгааны материал, мөрийн хөтөлбөрөө нийтэлж хүргэх байдлаар ажилласан байна.

Солонгосын туршлагыг харахад нам, нэр дэвшигчид нь үүссэн нөхцөл байдалд зохицон сонгуулийг амжилттай зохион байгуулахад

өөрсдийн зүгээс хувь нэмрээ оруулан чармайн ажилласан нь харагдана. Сонгогчдод мэдээлэл хүргэхдээ интернэт, гар утас болон бусад дэвшилтэт технологийг түлхүү ашиглан сонгогчдыг сонгуульдаа идэвхтэй оролцож санал өгөх идэвхийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан байх аж.

Манай нөхцөлд хэрэгжүүлэх боломж

Манай улсын хувьд цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 47-р зүйлд тусган зохицуулсан байна. Хэдийгээр хөдөө орон нутагт цахим технологи ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах нь төвөгтэй байж болох ч Монгол улсын нийт сонгуулийн насны хүн амын тал орчим хувь нь Улаанбаатарт оршин суудаг хотын иргэд байна. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зарим үзүүлэлтээс харахад 2019 оны байдлаар Монгол Улсад:

Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор -3,886,167

Ухаалаг утас хэрэглэгчдийн тоо- 2,439,236

Улс хоорондын интернэт багтаамж- 120 Gbps

Интернэт хэрэглэгчийн тоо- 2,910,000 байх ба зөвхөн фейсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2.2 сая, үүнээс гар утсаараа нийгмийн сүлжээнд холбогддог хэрэглэгч 2.1 сая байгаа нь улсын нийт хүн амтай харьцуулахад маш өндөр тоо болохыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас танилцуулсан мэдээллээс үзэж болно.⁴ Эндээс үзэхэд цахим технологийг сонгогчдод мэдээлэл хүргэх үр дүнтэй арга хэрэгсэл болгон ашиглах бүрэн боломжтой юм.

Солонгосын Үндэсний Ассамблейн сонгуулийн ололт

Солонгосын 2020 оны Үндэсний Ассамблейн сонгууль өндөрлөж санал хураах байрууд хаалгаа барих үед хоёр ч үзүүлэлтээр уг сонгуулийг амжилттай болсныг урьдчилж дүгнэж болохоор байв. ҮСХ сонгуулийг аливаа хийдэл гаргалгүй амжилттай зохион байгуулсан ба КОВИД-19-ийн эрсдэлээс үл хамааран сонгогчдын ирц өндөр байсан нь ҮСХ-ны авч хэрэгжүүлсэн шийдмэг арга хэмжээ үр дүнгээ өгсний илэрхийлэл байлаа.

Сонгуулийн ирц

2020 оны сонгуулийг товлосон хугацаанд нь зохион байгуулах амаргүй шийдвэр албан ёсоор гарсны дараа ҮСХ нь КОВИД-19-ийн тархалттай холбоотой янз бүрийн төвөгтэй асуудалтай нүүр тулсан бөгөөд энэ нь сонгуулийн үйл явц, үр дүнд сөргөөр нөлөөлж болохоор байв. Хамгийн их санаа зовоож байсан нэг асуудал нь санал хураах байранд хүн олноор цуглах тул халдварын эрсдэлээс болгоомжлон сонгогчид саналаа өгөхөөс цааргалж,⁵ улмаар сонгуулийн ирц доошилж сонгуулийн хууль ёсны буюу легитим чанарт сөргөөр нөлөөлөх вий гэсэн болгоомжлол байсан юм.

⁴ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ХЗДХЯ, ГБХЗХГ, НҮБ-ын хүүхдийн сан, Фэйсбүүк зэрэг байгууллагуудтай хамтран “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ” форум, 2019 оны 4-р сар <<https://ikon.mn/n/1jed>> сүүлд үзсэн огноо 2020 оны 5-р сарын 4

⁵ Гуравдугаар сарын дунд үеэр Францад болсон хотын дарга сонгох сонгууль, мөн үед Малид болсон Парламентын сонгуулиар сонгогчдын ирц эрс доошилсон байна.

2020 оны сонгуулийн хувьд дээрх болгоомжлолын эсрэг сонгогчдын ирц анхнаасаа маш өндөр хувьтай байлаа. Дөрөвдүгээр сарын 15-ны өдөр улс даяар нээгдсэн 14,330 санал хураах байрны гадна урд хожид нүүрлэж байгаагүй онцгой нөхцөлийг үл хайхран, халдвараас урьдчилан сэргийлэх зааврыг хариуцлагатай сахин санал өгөх ээлжээ тэвчээртэй хүлээсээр Солонгосын иргэд сонгуульдаа маш идэвхтэй оролцсон юм. ҮСХ-ноос урьдчилсан байдлаар танилцуулсан мэдээллээс үзэхэд нийт 44 сая бүртгэлтэй сонгогчийн 66 хувь нь сонгуульдаа оролцсон ба энэ нь 1992 оноос хойших хамгийн өндөр ирц⁶ болжээ. Үүнд сонгуульд санал өгөх нас 19 байсныг 18 болгон буулгасан сонгуулийн шинэчлэл ч нөлөөлсөн байх магадлалтайг дурдах нь зүйтэй.

Сонгуулийн ирцийн дээрх тоо баримтаас харахад ҮСХ-ны зүгээс сонгогчдыг идэвхжүүлж, халдварын эрсдэлээс үл хамааран сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж, ухуулах арга хэмжээ авсан нь маш үр дүнтэй байсныг илэрхийлнэ. ҮСХ нь сонгогчдын аюулгүй байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлж буй онцгой арга хэмжээнүүдийг, үндэслэл шалтгаантай нь хамт олон нийтэд хичээнгүйлэн мэдээлж, тайлбарлаж байсан. Ийнхүү санаачилгыг гартаа авч, ил тод байдлыг ханган идэвхийлэн ажилласнаар сонгогчдын хувьд халдварын эрсдэлийг бууруулах чиглэлээр ҮСХ-ны авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй гэж үзэн сонгуульдаа идэвхтэй оролцсон бол улс төрийн нам, нэр дэвшигчдийн хувьд сонгуулийн кампанит ажлыг уламжлалт хэлбэрээр явуулахад тулгарсан бэрхшээлийг үл хайрхан, хязгаарлагдмал нөхцөл байдалд нийцүүлэн сонгогчдод хүрэх шинэлэг арга технологи ашиглан ажилласан.

Сонгуульдаа идэвхтэй оролцсон Солонгосын сонгогчдын хувьд эрүүл мэндэд нь эрсдэлтэй цар тахлын хэцүүхэн нөхцөлд ч иргэний үүргээ өндрөөр ухамсарлан биелүүлэх хатуужилтай

болохоо батлан харууллаа. Саналаа өгөхөөс зайлсхийж болгоомжлохын оронд харин ч сонгох эрхийнхээ үнэ цэнийг улам мэдрэн сонгуульдаа олноороо идэвхтэй оролцох нь КОВИД-19-ийн эсрэг тэмцэж буй нэг хэлбэр гэж ойлгосон нь ч үүнд нөлөөлсөн нь гарцаагүй.

Сонгуулиас хойш хоёр долоо хоног гаруй хугацаа өнгөрөөд буй агаад энэ хугацаанд КОВИД-19-ийн халдварын тархалтыг хяналтдаа авсан хэвээр байгаа бөгөөд 4-р сарын 30-ны өдөр дотооддоо халдвар авсан тохиолдол огт бүртгэгдээгүй анхны өдөр болсныг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлсэн байна.⁷ ҮСХ-ноос авч хэрэгжүүлсэн шуурхай бөгөөд шийдэмгий арга хэмжээ нь үр дүнгээ ийнхүү өгснөөр зогсохгүй сонгогчдод хангалттай итгэл үнэмшил төрүүлж чадсан нь батлагдлаа.

Сонгуулийн сурталчилгаа

Дээр дурдсан тодорхой амжилтууд байвч цар тахлаас үүдсэн онцгой нөхцөл байдалд сонгууль явагдсантай холбоотой бэрхшээлтэй зарим асуудал гарцаагүй тулгарсан бөгөөд вирусийн халдварын эсрэг авсан шийдэмгий арга хэмжээнүүд нь сонгуулийн зарим үйл явцад таагүй нөлөө үзүүлэх тал ажиглагдсаныг дурдах нь зүйтэй.

Тухайлбал, үүссэн нөхцөл байдлын улмаас хэвийн явагдах боломжгүй болсон сонгуулийн нэг үйл явц нь сонгуулийн кампанит ажил байв. Хязгаарлагдмал нөхцөлд сонгуулийн кампанит ажлаа зохион байгуулахаас өөр аргагүй болсон нам, нэр дэвшигчдийн сурталчилгаа өмнөх сонгуулиудтай харьцуулахад цар хүрээ, үр нөлөө нь буурсан дүр зураг ажиглагдаж байв. Гэвч нийтийн эрүүл мэндийг хамгаалахын тулд авч хэрэгжүүлж буй халдварын эсрэг хатуу арга хэмжээ нь зайлшгүй шаардлагатай бөгөөд уламжлалт арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч эвлэрэх хандлага давамгайлж байв.

⁶ Өмнөх Үндэсний Ассамблейн сонгуулиудаар сонгогчдын ирц ямар байсныг АСДҮОУХ-гийн Сонгуулийн ирцийн өгөгдлийн сангаас үзэхэд 2016 онд 58,03, 2012 онд 54,26, 2008 онд тус тус 46,01 хувьтай байжээ.

⁷ South Korea has recorded its first day with no locally transmitted cases of Covid-19 since the middle of February. BBC 2020 оны 4-р сарын 30 < <https://www.bbc.com/news/world-asia-52482553> > сүүлд үзсэн огноо 2020 оны 5-р сарын 4

ДҮГНЭЛТ: СОЛОНГОСЫН ЦОО ШИНЭ ТУРШЛАГААС СУРАЛЦАХ ЗҮЙЛС

Дэлхий дахинаа КОВИД-19-ийн халдварын тархалт намжаагүй, ойрын хугацаанд намжих эсэх нь тодорхойгүй одоогийн нөхцөлд хэд хэдэн улс Өмнөд Солонгосын нэгэн адил ээлжит сонгуулиа товлосон хугацаанд нь зохион байгуулах эсэх, тэрчлэн эрүүл, аюулгүй орчин хэрхэн бүрдүүлэх талаар толгой гашилгаж байна. Тэгэхээр тус улсын эхлүүлсэн туршлагаас ямар сургамж авч түүх, нийгэм, улс төр, соёл, дэд бүтэц, эдийн засгийн хувьд ялгаатай улс орнууд хэрхэн ашиглах боломжтой вэ? гэдэг асуулт сонирхол татаж байна.

Өмнөд Солонгосын жишээнээс үзэхэд ҮСХ нь асар хүнд нөхцөл байдалд ажилласан ч алдаа гаргалгүй мэргэжлийн түвшинд сонгуулиа амжилттай зохион байгуулж чадсан. Гэвч энэ туршлагыг өөр өөрийн онцлогтой бусад улс орон шууд авч ашиглах боломжтой гэсэн үг биш юм. Сонгууль явуулах эрүүл, аюулгүй орчныг Солонгостой харьцуулахуйц түвшинд бүрдүүлэхэд бусад улс орны хувьд тодорхой урьдчилсан нөхцөл бүрдсэн байх нь туйлын чухал.

КОВИД-19-ийн тархалтыг үр дүнтэй хянах чадавх

Юуны өмнө зайлшгүй анхаарах асуудал бол КОВИД-19-ийн халдварын тархалттай тэмцэх улс орнуудын чадавх, дэд бүтэц, арга хэрэгсэл, тактик, үр дүн нь харилцан адилгүй байгаа бодит байдал юм. Улс орнуудын хувьд цар тахалтай тэмцэн тархалтыг бууруулах, цаашид нэмэгдүүлэлгүй хянахад чиглэсэн арга хэмжээ нь янз бүрийн шатанд явагдаж харилцан адилгүй үр дүнтэй байна. Манай улсын хувьд өмнө дурдсанчлан халдварын тархалтаас урьдчилан сэргийлж шуурхай арга хэмжээ авсны үр дүнд 2020 оны 5-р сарын 4-ний байдлаар нийт батлагдсан тохиолдол 40, үүнээс 12 хүн эдгэрсэн, эмчлэгдэж байгаа 28 хүн байв. Батлагдсан тохиолдлуудын хувьд бүгд гадаадад халдвар авсан тохиолдлууд байх бөгөөд одоогийн байдлаар дотоодод халдвар авсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Өмнөд Солонгос Улсын хувьд засгийн газар нь хамгийн анхны халдварын тохиолдол бүртгэгдсэний дараа хариу арга хэмжээ авахдаа нэлээд цаг хугацаа алдсан талтай ч дараа нь асар хурдан хариуцлагатай ажиллаж иргэддээ болоод бусад улсуудад халдварыг тогтоон барьж, тархалтыг намжаан хянах чадавхтай болохоо нотлон харуулсан билээ. Солонгос Улс хорио цээр тогтоож, иргэдийнхээ чөлөөтэй зорчих, шилжих хөдөлгөөнийг хатуу хязгаарлаагүй боловч санал хураах өдрийг хүртэлх хугацаанд халдвар авсан тохиолдлын тоог хяналтдаа байлгаж, тогтоон барьж чадсан.

Тэгэхээр КОВИД-19-ийн тархалтын нөхцөлд сонгууль зохион байгуулах шийдвэр гаргахад харгалзах гол шалгуур нь сонгуулийн үйл явц үргэлжлэх хугацаанд халдварын тархалтыг тогтоон хянах чадавх юм. Өмнөд Солонгосын хувьд Засгийн газар нь халдварын тархалтыг намжаан барьж чадсаны дээр ҮСХ-ноос авч хэрэгжүүлсэн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх арга хэмжээний үр дүнд сонгогчид айж эмээлгүй саналаа өгөх нөхцөл бүрдсэн ба энэ нь сонгуулийн ирц өндөр байхад нөлөөлсөн аж.

Сонгуулийн эрх зүйн орчин

Солонгосын ҮСХ-ноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сонгуультай холбоотой нийтийн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг багасгах, халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус улсын өмнөх сонгуулиудад болоод олон улсад ч урд өмнө огт гарч байгаагүй шинэ туршлага болсон. Эдгээр арга хэмжээг цаг алдалгүй, алдаа мадаггүй хэрэгжүүлэхэд сонгогчдын оролцоог хангахад чиглэсэн нарийвчилсан зохицуулалт бүхий сонгуулийн эрх зүйн орчин чухал урьдчилсан нөхцөл болсон юм. Сонгогч сонгуулийн өдрөөс өмнө урьдчилж биеэр болон алсаас санал өгөх процесс КОВИД-19-ийн тархалтаас өмнө хуульчлагдсан байсан бөгөөд дээрх заалтуудыг цар тахлын улмаас бий болсон нөхцөл байдалд тохируулан ашиглах боломжтой

байв. Урьдчилсан санал хураах зохицуулалтын хүрээнд сонгогч улс даяар байгуулагдсан санал хураах байруудын алинд ч хамаагүй очиж биеэр санал өгөх буюу заавал урьдчилж бүртгүүлэх шаардлагагүй байв. Түүнчлэн зарим эмзэг бүлэгт хамаарах сонгогчдын хувьд шуудангаар урьдчилж санал өгөх боломжтой байсан. Гадаадад оршин сууж буй бүртгэлтэй сонгогчдын хувьд бүгдийг нь хамруулах боломжгүй байсан ч чамлахааргүй олон сонгогч гадаадаас сонгуульдаа оролцож саналаа өгсөн дүнтэй байлаа. Солонгосын сонгуулийн эрх зүйн орчинд сонгогчдын оролцоог хангахад чиглэсэн дээрх боломжуудыг тусгаж зохицуулсан байхаас гадна ҮСХ-ны хувьд эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлж ирсэн туршлагатай ба зохион байгуулалт, процедур, үйл ажиллагааны талаас хуримтлуулсан мэдлэг, чадавхтай байгууллага болох нь мөн нөлөөлсөн юм.

Манай улсын хувьд дээр дурдсанчлан урьдчилж болон алсаас санал өгөх боломж сонгогчдод олгосон нарийвчилсан хуулийн зохицуулалт байхгүй ба сонгогчдын хувьд сонгуулийн өдөр санал хураах байранд биеэр ирж саналаа өгөхөөс өөр аргагүй байна. Энэ нөхцөлд санал хураах байрны эрүүл, аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлэх арга хэмжээг СЕХ-ноос зохих төрийн байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх нь тун чухал болж байна. Үүнд Солонгосын ҮСХ-ны гаргасан Сонгогчдод зориулсан санал өгөх журам, сонгуулийн ажилтнуудын дагах протокол, ариутгал халдваргүйжүүлэлтийн бусад үр дүнтэй арга хэмжээг загвар болгон ашиглах боломжтой юм.

Шаардлагатай хэрэгсэл, нөөцөөр цаг алдалгүй хангах

КОВИД-19-ийн тархалтын үед сонгуулийг үр дүнтэй зохион байгуулахад зайлшгүй шаардагдах нэг нөхцөл нь сонгогчдын эрүүл мэндэд эрсдэл үүсгэхгүй баталгаатай орчинд санал хураалтыг зохион байгуулахад шаардлагатай хэрэгсэл, бусад нөөцийг хүртээмжтэй байлгах явдал юм. Үүнд санхүүгийн эх үүсвэр, дэд бүтэц

болон бусад шаардлагатай технологи, харилцаа холбооны хэрэгсэл, хүний нөөц, ноу-хау, чадавх, журмаар зохицуулсан болон албан бус процедур, арга хэмжээ зэрэг багтах ба СЕХ нь шаардлагатай онцгой арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхэд дээрх нөөцийг хүрэлцээтэй хэмжээгээр хугацаа хожимдуулалгүй хангаж өгөх нь чухал юм.

Солонгосын Үндэсний Ассамблейн 21 дэх удаагийн ээлжит сонгуулийн зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлсэн зардлын нарийвчилсан мэдээлэл хараахан тодорхой болоогүй байв. Гэвч харьцангуй богино хугацаанд нарийн төвөгтэй үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд мэдээж нэлээд хөрөнгө санхүү шаардагдсан нь ойлгомжтой.

Улс төрийн таатай орчин

Бас нэг анхаарах хүчин зүйл нь улс төрийн таатай орчин бүрдүүлэх явдал юм. Үүнд янз бүрийн улс төрийн хүчин, оролцогч тал (үүнд сонгуульд өрсөлдөгч талууд) цар тахлаас үүдэн тулгараад буй нөхцөл байдлаас бий болсон хязгаарлалтуудад зохицон, сонгуулийн сурталчилгаа, кампанит ажлаа уламжлалт арга хэлбэрээр зохион байгуулах боломжгүйгээ хүлээн зөвшөөрөх нь гол асуудал болно. Ингэснээр СЕХ-ны хувьд ч хүнд нөхцөлд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг бүхий таатай нөхцөл бүрдэх сайн талтай.

Улс төрийн таатай нөхцөл гэдэгт улс төрийн нам, нэр дэвшигчдийг тэгш өрсөлдөх боломжоор хангах, эрх баригч нам нь томоохон хэмжээний хямралыг даван туулах явцдаа олж авсан давуу талыг тэгшитгэх арга эрэлхийлэх нь мөн чухалд тавигдана.

2020 оны УИХ-ын ээлжит сонгууль хаяанд ирсэн энэ цаг үед цар тахлын эрсдэл нүүрлэсэн нөхцөлд Өмнөд Солонгос Улсын сонгууль зохион байгуулсан туршлагаас манай улсын нөхцөлд авч хэрэгжүүлж болох зүйл нэлээд байгаа нь харагдлаа. Юуны өмнө, үүсээд буй онцгой нөхцөл байдалд сонгууль явуулахад СЕХ төдийгүй

сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд, сонгогчид нийлээд олон талын оролцоо, харилцан ойлголцол, хамтын ажиллагаа чухал болох нь харагдаж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд СЕХ-ны хувьд хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран сонгуулийн үйл явцын алхам тутамд халдварын эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг цогц байдлаар төлөвлөж, оролцогч талуудыг мэдээллээр хангах нь юу юунаас чухал аж. Үүнд, тухайлбал, сонгуулийн өдөр санал өгөхөд сонгогчдын дагаж мөрдөх журам заавар, санал авах байрны зохион байгуулалт, сонгуулийн ажилтнуудын дагаж мөрдөх журам, өвчний улмаас сонгох эрхээ эдэлж чадахгүй байх магадлалтай сонгогчид, тэднийг эмчилж буй эмч, эмнэлгийн ажилтнууд болон тусгаарлагдсан иргэдийн саналыг аюулгүй нөхцөлд авах

ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх гэх мэт арга хэмжээг төлөвлөн, зохих бэлтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна. Үүнд шаардагдах нөөц хөрөнгийг СЕХ-нд цаг алдалгүй гаргаж өгөх нь чухал болох нь тодорхой юм. Цар тахлын эрсдэлээс эмээсэн сонгогчид саналаа өгөхөөс цааргалснаар сонгуулийн ирц буурах эрсдэлээс сэргийлж халдваргүйжүүлэлт, ариутгалыг хэрхэн хийх, урьдчилан сэргийлэх бусад ямар арга хэмжээг хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх нь чухал болохыг Солонгосын туршлага харуулж байна. Эцэст нь ардчилсан шударга сонгуулийн гол зарчим болох ил тод байдлыг дээд зэргээр хангах нь сонгуулийн үйл явц, үр дүнд итгэх оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэхэд чухал хөшүүрэг болох бөгөөд манайд Солонгосын авч хэрэгжүүлсэнтэй ижил үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байгааг дурдах нь зүйтэй.

Хэрэгтэй линк:

- ҮСХ-ноос бэлтгэсэн видео: Сонгогч саналаа өгөхөд баримтлах журам/ Voter Code of Conduct in 20 Seconds
- ҮСХ-ноос бэлтгэсэн видео: Сонгуульдаа оролцож, аюулгүй орчинд саналаа урьдчилж өгнө үү/ Come and Vote Safely during Early Voting
- ҮСХ-ноос бэлтгэсэн видео: Сонгуульдаа оролцож, аюулгүй орчинд саналаа өгнө үү/ Come and Vote Safely on Election Day
- ҮСХ-ноос бэлтгэсэн видео, зураг: Сонгуульдаа оролцож, аюулгүй орчинд саналаа өгнө үү /Come and Vote Safely
- Үндэсний Ассамблейн 21 дэх удаагийн ээлжит сонгууль: Шууд дамжуулалт /Livestreaming